



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/338

Алтай хот

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд төсөв санхүүгийн зардал батлах, хөрөнгө зарцуулах болон хүний нөөцийн чиглэлээс бусад үндсэн үйл ажиллагааны чиглэлийн захирамж гаргах эрхийг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д олгосугай.

2.Захирамжийг хууль тогтоомжийн хүрээнд гаргаж, тухай бүр хэрэгжилт, үр дүнг танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

3.Энхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны "Ажлын чиг үүрэг батлах тухай" А/628, "Эрх шилжүүлэх тухай" А/649 дүгээр захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР